



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/796

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “в”, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.ХОАОНӨГ/201801060 гэрээний дугаартай Ховд, Дөргөн сум чиглэлийн замын ТЭЗҮ боловсруулах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ц.Ганданповрон – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Гишүүд:

Х.Өнерхан – Ховд сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын авто замын улсын байцаагч

З.Өмиртай – Аймгийн ерөнхий архитектор бөгөөд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Ж.Батлхагва – Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн

С.Батдорж – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Ц.Сувдаа – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн.

2.ХОАОНӨГ/201801060 гэрээний дугаартай Ховд, Дөргөн сум чиглэлийн замын ТЭЗҮ боловсруулах ажлыг ажлын даалгаварын дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН